



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/596.

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 "в", Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тушаалаар батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн төвийн авто зам нөхөх, уулзварын эргэлтийг өргөтгөх /Жаргалант сум/ ажлыг байнгын ашиглалтанд оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Х.Баярлах – Жаргалант сумын Засаг даргын
Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

И.Гантогтох – Цагдаагийн газрын Замын
цагдаагийн тасгийн ахлах, цагдаагийн хошууч

Б.Ганзориг – Мэргэжлийн хяналтын газрын авто
замын улсын байцаагч


Б.Түмэнжаргал – Орон нутгийн өмчийн газрын
өмчийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Ц.Сувдаа – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн зам тээвэр, уул уурхай, хүнд
үйлдвэрийн хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн

2.Аймгийн төвийн авто зам нөхөх, уулзварын эргэлтийг өргөтгөх /Жаргалант сум/ ажлыг ажлын даалгавар, зураг төсвийн дагуу, хуулийн хүрээнд байнгын ашиглалтанд авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Х.Баярлах/ – д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

Zax A/596 Ch

02 02679